



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/202.

Ховд

Гэрээ цуцлах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албанаас зохион байгуулсан СОЯ\2022\12002 дугаартай “Кино театрын барилга”-ын ажлын “Ховд баганат” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ нь “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа гэрээ байгуулна” гэсэн хуулийн заалтыг зөрчиж байгуулагдсан байх тул захирамж гарсан өдрөөр тасалбар болгон уг гэрээг цуцалсугай.

2. Гэрээг цуцалсан талаар “Ховд баганат” ХХК-д мэдэгдэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

